



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/463

Мандалговь


Гарын үсэг зурах эрхийг түр  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 3.2.3, 4.2.1, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 8.2-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Эрдэнэсүрэн нь аймгийн ЗДТГ-ын заалнуудын тавилга нийлүүлэх ДУГАОНӨГ/201812015 ажлын гэрээнд захиалагчийг төлөөлөх байсан боловч ашиг сонирхлын зөрчил үүсч байгаа тул Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга А.Ганбатаар захиалагчийг төлөөлүүлэн гарын үсэг зурах эрхийг түр шилжүүлэн гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. Аймгийн ЗДТГ-ын заалнуудын тавилга нийлүүлэх ДУГАОНӨГ/201812015 ажлын гэрээнд гарын үсэг зурах албан үүргийг гүйцэтгэхдээ хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010492